



ЗҮҮ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Зүү эмчилгээгээр өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
2. Эмнэлзүйн тохиолдолд суурилсан зүү эмчилгээний жорын сонголт, чихний зүү эмчилгээг хавсарсан туршлагын үр дүнгийн тайлан /холбогдох материалыг хавсаргах/;
3. Зүү эмчилгээний өвчнөөс урьдчилан сэргийлэх сувгийн сүвийн үйлчлэл, тамхинаас гаргах, тураах үеийн чихний зүү эмчилгээг хийсэн тайлан /бичлэг, CD ирүүлэх/;
4. Сургалт эрхлэгч байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдан багц цагийн бүрдүүлэлтийн 50%-ийг бүрдүүлсэн байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Зүү эмчилгээ судлалаар мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх;
2. Зүү эмчилгээгээр өвчнөөс урьдчилан сэргийлэх аргын тухай нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг бүс нутагт зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
3. Ховор тохиолдох эмнэлзүйн тохиолдлын үеийн Зүү эмчилгээний жор, гарын зүү эмчилгээг хавсран эмчилсэн тухай тайлан /холбогдох материалыг хавсаргах/;
4. Төрөл бүрийн өвдөлт намдаах, цусны даралт буулгах, нойргүйдлийг эмчлэх, ходоодны агилтыг бууруулах зорилгоор гарын зүү эмчилгээг хийсэн тайлан /CD ирүүлэх/;
5. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, бүтээл хэлэлцүүлж, анагаах ухааны мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл, хэвлэлд нийтлүүлсэн байх,
6. Сургалт эрхлэгч байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо /зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдан багц цагийн бүрдүүлэлтийн 50%-ийг бүрдүүлсэн байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Удирдахуйн болон мэргэшлийн чиглэлээр эмнэлзүйн сургагч багш болсон байх;
2. Зүү эмчилгээгээр өвчнөөс урьдчилан сэргийлэх аргын тухай нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
3. Зүү эмчилгээний төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр ажилласан тайлан;
4. Зонхилон тохиолдох өвчин, түүний хүндрэл, ховор тохиолдох эмгэгийн үеийн Зүү эмчилгээний чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шатлалын эмнэлэгт зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай байх;
5. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гардан хийж хэвлүүлсэн байх, үүний 2 нь олон улсын хуралд илтгэгдэж, мэргэжлийн хэвлэлд нийтлэгдсэн байх;
6. Сургалт эрхлэгч байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдан багц цагийн бүрдүүлэлтийн 50%-ийг бүрдүүлсэн байх.